

Атомуудын өдөөгдсөн төлөвүүдийн энергийг Кон-Шэмийн тэгшитгэлээр тооцоолох нь

Д.Наранчимэг^{1,*}, Л.Хэнмэдэх¹, Г.Мөнхсайхан¹, Н.Цогбадрах²

¹Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль, Физикийн тэнхим

²Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Байгалийн Ухааны Салбар, Физикийн тэнхим

Нягтын функционалын онолын Кон-Шэмийн тэгшитгэлээр He, Li, Be-ын атомуудын нэг болон хоёр удаа өдөөгдсөн төлөвүүдийн нягт ба энэргийг тооцоолсон. Кон-Шэмийн тэгшитгэлийг бөмбөлөг координаттай системд Кулоны долгион функцтэй дискрет хувьсагчийн аргаар бодсон. Энд координатыг жигд биш, оптималиар дискретчилж, нарийвчлал сайтай шийдийг гаргаж авна. Тооцооны үр дунгүүдийг Рой нарын псевдоспектриал аргаар тооцоолсон болон туршлагын үр дунтэй харьцуулахад He-ийн хоёр удаа өдөөгдсөн төлөвүүдийн энэргийн зөрүү 0.001-0.016, Li-ийн өдөөгдсөн төлөвүүдийн энэргийн зөрүү 0.0041-0.295% Be-ийн өдөөгдсөн төлөвүүдийн энэргийн зөрүү 0.02-1.51% байна.

PACS numbers: 31.15.E-, 31.15.xr, 31.25.Jf.

I. ОРШИЛ

Нягтын функциональ онол (НФО) нь Хонберг-Кон [1] ийн хоёр теорем дээр үндэслэгддэг хатуубие, молекул, атомын электроны бүтцийн тооцооллыг хийдэг квант механикийн арга юм. Кон-Шэмийн тэгшитгэлүүд нь 3 хэмжээст огторгуйд Хартри-Фокийн тэгшитгэлүүдтэй ижил боловч олон биений харилцан үйлчлэл нь локаль солилцоо-корреляцийн потенциалаар илэрхийлэгддэг [2]. Энэ өгүүлэлд Кон-Шэмийн тэгшитгэлийг бөмбөлөг координатын системд Кулон долгионтой Дискрет хувьсагчийн аргаар бодсон [3]. Энэ арга нь Кулоны бүрэн базтай атомын системд тохирдог төдийгүй олон электронт системийн төлөвийн шинж чанарыг тооцоолоход эхлээд хуурмаг хугацаанаы аргыг ашиглан Кон-Шэмийн тэгшитгэлийг дифференциаль тэгшитгэлд шилжүүлнэ. Энэ өгүүлэлд ортонональ полином болон Кулоны долгион функцээр үүсгэгдсэн Дискрет хувьсагчийн аргыг товч танилцуулж, цаашид олон электронт атомын системийн Кон-Шэмийн тэгшитгэлд хэрхэн ашиглагдах талаар авч үзнэ. Тооцооны үр дунгүүдийг бусад ажлууд болон туршлагын үр дунтэй харьцуулсан ба энэ ажлын тооцоог атомын нэгжид хийсэн.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Дискрет хувьсагчийн аргыг Харрис нар [4] үндэслэсэн бөгөөд Дикинсон ба Сершин нар [5]

өргөтгөсөн. Квант механикийн бодлогыг бодоход Дискрет хувьсагчийн аргыг ашиглах анхны оролдлогуудыг Лайт нар [6] хийсэн бөгөөд үүнээс хойш физик, химийн шинжлэх ухааны төрөл бүрийн салбаруудад өргөн хэрэглэгддэг болсон. Энэ аргаар Гамильтонианыг матрицын элементэд шилжүүлдэг бөгөөд ихэнх тохиолдолд кинетик энэргийг матрицид шилжүүлснээр дифференциаль тэгшитгэлийг алгебрийн тэгшитгэлд шилжүүлнэ. ψ_j орбиталиудаар тодорхойлогдох хугацаанаас хамаарсан Кон-Шэмийн тэгшитгэл нь

$$i \frac{\partial \psi_j(\vec{r}, t)}{\partial t} = (\hat{H}_0 + v_{eff}) \psi_j(\vec{r}, t), j = \overline{1, N} \quad (1)$$

хэлбэртэй бичигддэг. Энд \hat{H}_0 нэг электроны атомын Гамильтониан, v_{eff} -хугацаанаас хамаарсан эффектив потенциал нь электрон-электроны түлхэлцэл, цөм-электроны таталцал, солилцоо ба корреляцийн потенциалуудаас бүрдэнэ. $\psi_j(\vec{r}) = R_{nl}(r)Y_{lm}(\Omega)$ нэг электроны орбитал болно.

Атомын электроны нягт нь орбиталуудын модулийн квадраттай тэнцүү:

$$\rho(\vec{r}, t) = \sum_{j=1}^N |\psi_j(\vec{r}, t)|^2. \quad (2)$$

$\psi_j(\vec{r})$ гэсэн j -р орбиталыг тодорхойлохдоо $\psi_j \cong \Psi_{n00} \cong \Psi_{ns}$, $\psi_j \cong \Psi_{n00} \cong \Psi_{np}$ байхаар тодорхойлсон. Гелийн атомын хувьд

* Electronic address: naranchimeg@must.edu.mn

солилцооны энергийн тодорхой хэлбэрийг сонгож болдог ба харин бусад системүүдэд энергийн функционалын локаль хэлбэрүүдийг сонгож авдаг [7]. Энэхүү тооцоонд корреляцийн энергийн функционалыг Вигнерийн томъёогоор бодсон. Энэ функционалыг хүчтэй лазер атомын харилцан үйлчлэл, молекул систем, атомын үндсэн ба өдөөгдсөн төлөвүүдэд бүгдэд нь хэрэглэж болдог.

Тэгшитгэлийн тоон шийд: (*Дискрет хувьсагчийн арга*)

Кон-Шэмиин тэгшитгэл (1) - р тэгшитгэлийг бодохын тулд бөмбөлөг координаттай системд 2-р эрэмбийн операторын хуваалтын схемийг ашиглан Δt хугацааны алхамтайгаар долгион функцийн бичвэл:

$$\psi(\vec{r}, t + \Delta t) = e^{-i\Delta t_2^1 \hat{H}_0} e^{-i\Delta t V} e^{-i\Delta t_2^1 \hat{H}_0} \psi(\vec{r}, t) \quad (3)$$

болно. Кулоны долгионтой дискрет хувьсагчийн аргаар Кон-Шэмиин тэгшитгэлийг бодоход радиал зангилааны цэгүүдээр Кулоны функцийг тодорхойлох ба $\psi(r)$ функцийг $\psi_N(r)$ – аар ойролцоолно

$$\psi(r) \cong \psi_N(r) = \sum_{j=0}^N \psi(r_j) g_j(r). \quad (4)$$

(4) тэгшитгэл дэх $\psi(r_j)$ -нь интерполяцийн функци, $g_j(r)$ кардинал функци бөгөөд $g_j(r)$ –ийг

$$g_j(r) = \frac{1}{F'(r_j)} \frac{F(r)}{r - r_j} \quad (5)$$

байдлаар тодорхойлогдоно. Энд: $F(r)$ - Кулоны функци, $F'(r)$ - r_j дээрх 1-р эрэмбийн уламжлал болох ба кардиналийн нөхцөл нь $g_j(r_i) = \delta_{ji}$ байна. Интерполяцийн функцийг атомын Гамильтониантай радиал тэгшитгэлд орлуулбал:

$$\hat{H}(r)\psi(r) = E\psi(r). \quad (6)$$

болно. (6)-р тэгшитгэл нь Кон-Шэмиин радиал тэгшитгэл буюу хувийн утгын бодлогыг бодно. Атомын Гамильтониан $\hat{H}(r) = -\frac{1}{2} \frac{d^2}{dr^2} + V(r)$ байна.

\hat{H} Гамильтонианыг дискретчилж Кон-Шэмиин тэгшитгэлийн системийг бичвэл

$$\sum_{i=1}^N \left[-\frac{1}{2} T_{ji} + V(r_i) \delta_{ji} \right] \phi_{kj} = \varepsilon_k \phi_{kj} \quad (9)$$

хэлбэртэй бичигдэнэ. Энд: ϕ_k - хувийн функци, ε_k - хувийн утга бөгөөд T_{ji} кардинал

функцийг 2-р эрэмбийн уламжлалаар тодорхойлдог.

$$(T)_{ji} = \frac{1}{3} \left(E + \frac{Z}{r} \right), j = i \quad (7)$$

$$(T)_{ji} = \frac{1}{(r_j - r_i)^2}, j \neq i. \quad (8)$$

Энд $e^{-\hat{H}_l^0 \Delta t / 2} \equiv S(l)$ эволюцийн операторыг \hat{H}_l^0 –оор нарийвчлал сайтай илэрхийлсэн явдал нь (3) тэгшитгэл дэх хугацааны алхамд хийсэн онцлог өөрчлөлт юм. Дискрет хувьсагчийн аргаар торын дискретчилэлийг оновчтой хийж, \hat{H}_l^0 операторын хувийн утгын бодлогын нарийвчлалыг сайжруулснаар энэ аргыг өргөжүүлдэг. Энэ ажилд Кон-Шэмиин систем тэгшитгэлүүдийг бодох, радиал координатуудыг дискретчилэх зорилгоор 152 цэг дээр, $\Delta t = 0.001 \text{ a.u.}$ бүхий хугацааны алхамтайгаар бодолтыг гүйцэтгэсэн болно.

III. ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэ ажилд He, Li, Be атомуудын нэг ба хоёр удаа өдөөгдсөн төлөвүүдийн энергийг Кон-Шэмиин тэгшитгэлээр тооцоолж, Рой нарын [8] псевдоспектриал аргаар тооцоолсон үр дүнтэй харьцуулсан болно. Энэ аргаар дээрх атомуудыг тооцоолсон үр дун хараахан хийгдээгүй бөгөөд бид энэхүү тооцоололд Кулоны долгион функцийн эффектив цэнэгийг $Z = 400$, долгион тоог $k = 3$, радиал зангилааны цэгийн тоог 152 байхаар сонгон авсан. 1-р хүснэгтэд Не-ийн хоёр удаа өдөөгдсөн ns^2 ($n=2,3,4,5$) синглет төлөвийн энергийг тооцоолсон тооцооллын үр дүнг нэгтгэн харуулав. Тооцооллын үр дүнгээс үзвэл Не-ийн хоёр удаа өдөөгдсөн төлөвүүдийн энергийг Рой нарын тооцоолсон энергиэс 0.115-1.832%-иар зөрүүтэй байна. Li атомын нэг удаа өдөөгдсөн $1s^2 ns^2 S$ ба $1s^2 np^2 P$ төлөвүүдийн, Be атомын нэг удаа өдөөгдсөн $1s^2 2sns^3 S$ ба $1s^2 2snp^3 P$ төлөвүүдийн энергүүдийг тооцоолж гарсан үр дүнг 2 ба 3-р хүснэгтүүдэд үзүүлсэн болно. Li ба Be-ийн нэг удаа өдөөгдсөн төлөвүүдийн энергийг Рой нарын үр дүнтэй харьцуулбал зөрүү нь 0.0041-0.295% ба 0.02-1.51% байна.

Хүснэгт 1. *Нэ-ийн хоёр удаа өдөөгдсөн төлөвийн энергийг тооцоолсон үр дүн (а.н.).*

Төлөв	-E	-E ¹
$2s^2 \ ^1S$	0.7673(0.130)	0.7663
$3s^2 \ ^1S$	0.3453(0.115)	0.3457
$4s^2 \ ^1S$	0.1929(1.832)	0.1965
$5s^2 \ ^1S$	0.1295(1.544)	0.1275

¹A. K. Roy and S. I. Chu, Phys. Rev. A 65, 052508 (2002).

Хүснэгт 2. *Li-ийн нэг удаа өдөөгдсөн төлөвийн энергийг тооцоолсон үр дүн (а.н.).*

ТӨЛӨВ	-E	-E ¹
$1s^2 3s \ ^2S$	7.3473	7.3577
$1s^2 4s \ ^2S$	7.3142	7.3197
$1s^2 5s \ ^2S$	7.3036	7.3046
$1s^2 \ 2p \ ^2P$	7.3901	7.4120
$1s^2 \ 3p \ ^2P$	7.3379	7.3386
$1s^2 \ 4p \ ^2P$	7.3160	7.3126
$1s^2 \ 5p \ ^2P$	7.3002	7.3005

¹A. K. Roy and S. I. Chu, Phys. Rev. A 65, 052508 (2002).

Хүснэгт 3. Ве-ийн нэг удаа өдөөгдсөн төлөвийн энергийг тооцоолсон үр дүн (а.н.).

Төлөв	-E	-E ¹
$1s^2 2s3s \ ^3S$	14.432	14.4291
$1s^2 2s4s \ ^3S$	14.342	14.3700
$1s^2 2s5s \ ^3S$	14.347	14.3499
$1s^2 \ 2s2p \ ^3P$	14.346	14.5666
$1s^2 \ 2s3p \ ^3P$	14.387	14.3979
$1s^2 \ 2s4p \ ^3P$	14.391	14.3591
$1s^2 2s \ 5p \ ^3P$	14.391	14.3393


¹A. K. Roy and S. I. Chu, Phys. Rev. A. 65, 052508 (2002).

Үүний зэрэгцээ тооцооллын үр дүнгээр зурагдсан Li-ийн $1s^2 3s$ төлөвийн радиал нягт, координатын хамаарлын графикийг 1-р зурагт харуулсан байна.

Судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

1. Кулоны долгионтой дискрет хувьсагчийн аргаар Кон-Шэймийн тэгшитгэлийг алгебрийн тэгшитгэлд шилжүүлэн радиал нягт, өдөөгдсөн төловийн энергийг тооцолсон.

Тооцооллын үр дүнгүүдийг Рой нарын [8] псевдоспектриал аргаар бодсон үр дүнтэй маш сайн тохирч байсан.



Зураг 1. Li $1s^2 3s$ төлөвийн радиал нягтын график

Цаашид энэ аргаар атомуудын төлөвийг нэмэгдүүлэн тооцоолол хийх, цөөн электронт атомын хувьд иончлолын тооцоог хийх боломжтой нь харагдаж байна.

АШИГЛАСАН НОМ

- [1] P. Hohenberg and W. Kohn, Phys. Rev. B 136, 864 (1964).
 - [2] R. G. Parr and W. Yang, Density-Functional Theory of Atoms and Molecules (Oxford Univ. Press, New York, 1989).
 - [3] Liang-You Peng and Anthony F. Starace J. Chem. Physics 125, 154311 (2006).
 - [4] B. K. Dey 110, 6229 (1999).and B. M. Deb, J. Chem. Phys.
 - [5] A. S. Dickinson and P. R. Certain, J. Chem. Phys. 49, 4209, 1968.
 - [6] J. V. Lill, G. A. Parker, and J. C. Light, Chem. Phys. Lett. 89, 483, 1982; R. W. Heather and J. C. Light, J. Chem. Phys. 79, 147, 1983; J.
 - [7] S. K. Ghosh and B. M. Deb, J. Phys. B: At. Mol. Opt. Phys. 27, 381 (1994).
 - [8] A. K. Roy and S. I. Chu, Phys. Rev. A. 65, 052508 (2002).